

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 21/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хорооны (МБХ) 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлого, мөнгөний бодлогын хэрэгжилт болон Монголбанкнаас цар тахлын үед хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг хэвийн горимд шилжүүлэх төлөвлөгөөний танилцуулгыг сонсож, бодлогын хүү, Төв банкны урт хугацаат дахин санхүүжилтийн хэмжээг тогтоох талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдааны эхний хэсэгт Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчинд гарч буй гол өөрчлөлтүүд, КОВИД-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийг танилцуулав.

Инфляц 2021 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 6.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.7 хувьтай байна. Инфляцад нэг талаас эдийн засгийн сэргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, түр зуурын шинжтэй нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байгааг онцлов. Тодруулбал, жилийн инфляц Улаанбаатар хотод 3 дугаар сараас 5 дугаар сард 4.7 нэгж хувиар өсөхөд мах, хатуу түлш болон шатахууны үнийн өсөлт 4.1 нэгж хувийг бүрдүүлжээ. Суурь төсөөллөөр богино хугацаанд нийлүүлэлтийн болон суурь үеийн шалтгаантайгаар инфляц нэмэгдэх төлөвтэй байна. Үүнд, 1) мах болон сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт хүлээлтээс өндөр, 2) дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийг дагаж дотоодын шатахууны үнийн төсөөлөл нэмэгдэх, 3) сайжруулсан түлшний үнийг хямдруулсан суурь үеийн нөлөө нь 2021 оны 4 дүгээр улирал, 2022 оны 1 дүгээр улирлын инфляцыг нэмэгдүүлэх нэг удаагийн шинжтэй нөлөө голлон тайлбарлахаар байна. Харин эрэлтийн хүчин зүйлсийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө нь эдийн засгийн идэвхжлийг даган аажмаар нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд дунд хугацаанд инфляц төв банкны зорилтот түвшний орчимд ($6\% \pm 2\%$) хадгалагдах хүлээлт хэвээр байгааг танилцууллаа.

МБГ-аас 2021 оны эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлж байгааг танилцуулав. Үүнд, эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд боловсруулах, худалдаа болон үйлчилгээний салбарын өсөлт сайжирч, уул уурхайн бус салбарын өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэх хүлээлттэй

байгаа нь нөлөөллөө. Харин БНХАУ хилийн хяналтаа чангатгаж нүүрс экспортлох автомашины тоог бууруулсан нөлөөгөөр нүүрсний үйлдвэрлэл буурч, уул уурхайн салбарын өсөлт өмнөхөөс буурахаар байна. Хэдийгээр 2021 оны 2 дугаар сард бүх нийтийн бэлэн байдалд шилжин, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон ч 1 дүгээр улирлын уул уурхайн бус салбар, тэр дундаа боловсруулах, худалдааны салбарын өсөлт хүлээлтээс өндөр байгааг онцлов. Дунд хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн салбарууд цар тахалтай холбоотой уналтаас гарч дотоод эрэлт сэргэснээр уул уурхайн бус салбар идэвхжихээр байгааг танилцууллаа. Гэсэн хэдий ч эдийн засгийн цаашдын төлөв цар тахлын дотоод тархалтаас хамаарахаар байна.

Нэгдсэн төсвийн нийт орлого 2021 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 2.3 их наяд төгрөгөөр (64 хувиар), Оюу толгойн татварын маргаантай холбоотой бүртгэсэн орлогыг хасч тооцвол 1.3 орчим их наяд төгрөгөөр (36 хувиар) нэмэгджээ. Төсвийн нийт зардал эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр (25 хувиар) нэмэгдсэн байна. Улмаар төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2021 оны 5 дугаар сарын байдлаар 866 тэрбум төгрөгт хүрчээ. Оюу толгойн татварын маргаантай холбоотой бүртгэсэн орлогын нөлөөг хасч тооцвол төсөөллөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого батлагдсан дүнгээс 400-500 орчим тэрбум төгрөгөөр дутахаар байгаа бөгөөд төсвийн зардалд тохируулга хийж, нэгдсэн төсвийн тэнцлийг энэ онд батлагдсан түвшинд байхаар авч үзэв.

Үргэлжлүүлээд, M2 мөнгө болон зээлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг дэлгэрэнгүй танилцууллаа. M2 мөнгө 2021 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар (6.3 их наяд төгрөгөөр) өсөв. Үүнд актив талаас гадаад цэвэр актив болон зээлийн өсөлт голлон нөлөөлжээ. Мөн Засгийн газрын цэвэр зээл эерэг нөлөөг үзүүлж байна. Харин 2020 онд M2 мөнгөний өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байсан зээлийн өсөлт энэ оны 1 дүгээр улирлаас эхлэн эерэг нөлөөтэй болсныг онцоллоо. M2 мөнгөний өсөлтийг эх үүсвэр талаас төгрөгийн харилцах, хадгаламж голлон бүрдүүлж, эх үүсвэрийн долларжилт үргэлжлэн буурч байгааг дурдав. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилт болон эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор банкны системийн шинээр олгож буй зээлийн өсөлт нэмэгдэж байгааг МБГ-аас танилцуулав. Тухайлбал, банкны системээс 2021 оны эхний 5 сарын

байдлаар нийт 10 их наяд төгрөгийн зээл олгосон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 35 хувиар өссөн үзүүлэлт юм.

Банкны системээс нийт шинээр олгож байгаа зээлийн хүү (хөнгөлөлттэй хүүтэй зээлийг оруулаад) 2021 оны 1 дүгээр сараас 3.7 нэгж хувиар буурч, 5 дугаар сард 11.5 хувьд хүрлээ. Хөнгөлөлттэй хүүтэй зээлийн нөлөөг хасч тооцвол 2021 оны 5 дугаар сард шинээр олгосон зээлийн хүү 1 дүгээр сараас 0.6 нэгж хувиар буурч, 14.8 хувь байна.

Гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгааг онцлов. Тухайлбал, томоохон эдийн засагтай орнууд болох БНХАУ, Евро бүс болон АНУ-ын 2021 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаад эрэлтийн төлөв өмнөх төсөөллөөс сайжирлаа. Цаашид КОВИД-19 вирусн эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байгааг дурдав. Мөн гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирсан бөгөөд үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Ийнхүү гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа хэдий ч дэлхий нийтээр цар тахалтай холбоотойгоор нийлүүлэлт, тээвэрлэлтийн асуудал үүсч, дэлхийн хүнсний үнийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэж байгааг дурдлаа.

МБГ-ын зүгээс төлбөрийн тэнцлийн ашиг 2021 онд өмнөх төсөөллөөс нэмэгдэх төлөвтэй байгааг танилцуулав. Ийнхүү төлбөрийн тэнцлийн төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд худалдааны нөхцөл сайжирсан, санхүүгийн дансны орох урсгал нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Гадаад эмзэг байдлыг илэрхийлдэг үзүүлэлтүүд төдийлөн өөрчлөлтгүй байгаа бөгөөд харин урсгал тэнцэл/ДНБ үзүүлэлт 2020 онд -5.1 хувь болж буурч, цаашид аажмаар нэмэгдэх хандлагатай байна.

МБХ-ны хуралдааны хоёрдугаар хэсэгт Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (НУСЗЗГ)-аас мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар танилцуулав. Танилцуулгын эхэнд ТБҮЦ-ны үлдэгдэл 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6 орчим их наяд төгрөгөөр нэмэгдсэн болохыг онцлов. ТБҮЦ-ны өсөлтийн шалтгаан нь эдийн засгийн өсөлт, төлбөрийн тэнцлийн ашиг, М2 мөнгөний нийлүүлэлтийн тэлэлт болон банкны системийн балансын өсөлттэй холбоотой байна.

Репо арилжааны хувьд МБХ-ны хурлаар цар тахлаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах, зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 9 дүгээр сард репо арилжааны хугацааг 2 жил болгож сунгасан ба МБХ-ны 3 удаагийн шийдвэрээр 830 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна. Үүнээс банкуудаас ирүүлсэн саналын дагуу 755 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5 удаагийн арилжаагаар банкуудад олгов. Банкууд 6 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нийтдээ 791.4 тэрбум төгрөгийн 3103 харилцагчийн зээлийг судалснаас 522.6 тэрбум төгрөгийн 2373 зээлдэгчийн хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Олгосон зээлүүдийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл худалдаа болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн хэмжээ нийт зээлийн 50 гаруй хувийг эзэлж байгааг онцлов.

Үргэлжлүүлээд, мөнгөний бодлогын хэрэгсэл болох заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хэрэгжилт, хангалтын талаар танилцууллаа. 2020 онд 2 удаагийн МБХ-ны хурлын шийдвэрээр 4.5 нэгж хувиар бууруулж 6.0 хувьд хүргэсэн. Үүнтэй холбоотойгоор 2021 онд төгрөгийн ЗБН-ийн нийт хангалт дунджаар 1.2 орчим их наяд төгрөгөөр тогтоогдсон ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 22.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Нөгөө талд, гадаад валютын ЗБН-ийн хувь хэмжээ 15 хувьд хэвээр байгаа бөгөөд 2021 оны нийт хангалтын хугацаанд дунджаар 1.2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээгээр тогтоов.

Төв банкны байнгын санхүүжилтийн хэрэгсэл овернайт хадгаламжийн хувьд 2021 оны 5 сарын байдлаар 349 удаа хийгдэж, хуримтлагдсан дүнгээр 19.8 орчим их наяд төгрөг татав. Нөгөө талдаа репо санхүүжилтийн 8 удаагийн хэлцлээр нийт 380 орчим тэрбум төгрөгийг банкуудад олголоо. Эдгээр хэрэгслүүдийг ашигласнаар банк хоорондын захын хүүний хэлбэлзэл харьцангуй бага, 2021 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар дунджаар 6.1 хувьтай байна.

Монголбанкны валютын зах дахь оролцооны хувьд 2021 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар 1223.3 сая ам.доллар худалдан авч, 693.2 сая ам.долларын валют худалдсан буюу цэвэр дүнгээр 530.1 сая ам.доллар татлаа. Үүнийг 2020 оны мөн үетэй харьцуулвал цэвэр оролцоо нь 1.1 орчим тэрбум ам.доллараар буурчээ. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн харьцангуй тогтвортой буюу -0.02 хувиас 0.02 хувийн хооронд хэлбэлзэж байгааг онцлов.

МБХ-ны хуралдааны дараагийн хэсэгт Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (ББӨБГ)-аас Монголбанкнаас цар тахлын үед хэрэгжүүлж буй

хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг хэвийн горимд шилжүүлэх төлөвлөгөөг танилцуулав.

КОВИД-19 цар тахлаас үүдэн төв банкнаас 2020 оны 3 дугаар сард активын ангиллын журам, зохистой харьцааны журмууд дээр тавигддаг шаардлагуудыг 6 сарын хугацаатай зөөлрүүлсэн бөгөөд нөхцөл байдал хэвийн байдалдаа шилжихгүй, цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор 2 удаа сунгагдсанаар одоо мөрдөгдөж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэвийн горимд шилжүүлэхээр байгааг танилцууллаа. Түүнчлэн, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 7.9 их наяд төгрөгийн зээл КОВИД-19-д өртсөн байгаа нь банкны системийн нийт зээлийн багцын 44 хувийг эзэлж байна.

Үргэлжлүүлээд, ББӨБГ-аас банкны салбарт тулгарч байгаа нөхцөл байдлыг үнэлж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс одоо мөрдөгдөж буй хөнгөлөлттэй зохицуулалтуудыг хэвийн горимдоо хэрхэн шилжүүлэх хувилбар төлөвлөгөөг танилцуулав. Ингэхдээ хувилбар төсөөллүүдийг хооронд нь харьцуулахад ашиглаж болох бүтэц өөрчилсөн зээлийн эрсдэлийг үнэлэх харьцаа үзүүлэлтүүдийг тодорхойлов. Эдгээр харьцаа үзүүлэлтүүд болон өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл цар тахлын үеийн төв банкнаас хэрэгжүүлж буй хөнгөлөлтийн арга хэмжээг дуусгавар болгох үед банкуудын үйл ажиллагаа нь КОВИД-19-д өртсөн ба бүтэц өөрчлөгдсөн зээлийн харьцаа, зээлийн чанар хэрхэн өөрчлөгдөх, цар тахлын халдварын тархалт болон Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн богино хугацааны үр дүнгээс ихээхэн хамаарахаар байна.

Түүнчлэн, КОВИД-19-ын тархалт, эдийн засаг, банк санхүүгийн системийн нөхцөл байдал хүлээлтээс өөр байх тохиолдолд авах арга хэмжээний хувилбаруудыг муу, дунд, сайн сценарийн хувьд танилцуулсан бөгөөд арга хэмжээ тус бүрийн үргэлжлэх хугацааг илүү уян хатан байдлаар тогтоох шаардлага үүсч болохыг онцлов. Мөн эдгээр боловсруулсан төлөвлөгөө, хувилбар, тооцоо судалгааг Монголбанкны Банкны хяналт, шалгалтын хороонд танилцуулан, эцсийн шийдвэрийг гаргана гэдгийг дурдлаа.

МБХ-ны хуралдааны төгсгөлд нь МБГ-аас оруулж ирсэн бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, Монголбанкаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх саналуудыг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Зарим гишүүд энэ удаагийн хурлаар бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг дэмжиж, харин урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар улиралд олгох хэмжээг бууруулах саналтай байв. Харин өөр нэг гишүүн 2021 оны 2 дугаар улиралд урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 350 хүртэлх тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 3 дугаар улиралд 250 хүртэлх тэрбум төгрөг болж буурч байгааг онцлов. Түүнчлэн 2020 оны 11 дүгээр сарын МБХ-ны хурлаар бодлогын хүүг 6 хувьд хүргэж бууруулсан шийдвэрийн эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дүн бүрэн илрээгүй, үргэлжлэн нөлөөлж буй тул бодлогын хүүг 6 хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн санал дэвшүүллээ. Бас нэг гишүүний хувьд бодлогын хүүний доод түвшин 6 хувь, үүнийг бууруулах орон зай байхгүй гэдгийг онцолж, эдийн засагт зарим сэргэлтүүд ажиглагдаж байгаа хэдий ч бодлогын хүүг бууруулсны нөлөө бүрэн гараагүй, бодлогын хүүг өсгөх нь хугацааны хувьд эрт байгаа тул энэ удаагийн хурлаар бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах саналтай байв.

Өөр нэг гишүүний хувьд урт хугацаат дахин санхүүжилт нь банкны системд эерэг нөлөөтэй, эрсдэл багатай хэрэгсэл болохыг онцолж, хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг дэмжиж байгаагаа илэрхийлэв. Үргэлжлүүлээд, бодлогын хүүг хэт удаан бага түвшинд хадгалах нь бодлогын хүүний үр нөлөөг бууруулах эрсдэлтэй болохыг анхааруулж, түүнчлэн макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа учир бодлогын хүүг өсгөх саналтай байв. Гэвч МБХ-ноос эдийн засгийн нөхцөл байдал, учирч болох эрсдэл мөн бодлогын хүүг 6 хувьд хүргэж бууруулсны нөлөө эдийн засагт бүрэн гараагүй байгааг харгалзан үзээд бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн нэгдсэн байр суурьт хүрлээ.

Ийнхүү, МБХ-ны гишүүд бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, Монголбанкаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх саналуудыг олонхын саналаар дэмжлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эдгээрийн ирээдүйн хандлага, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.